



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 254

Улаанбаатар хот

Барилгын тусгай зөвшөөрлийг шинээр олгох, сунгах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 15 дугаар зүйлийн 15.14.3, 15.14.6, Барилгын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 20 дугаар зүйлийн 20.3, 20.5, 20.6, 33 дугаар зүйлийн 33.1.15, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 147 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ-ын 2021 оны 11 дугаар сарын 11-ний өдрийн 21/750/ГЗ тоот албан бичгээр ирүүлсэн саналын дагуу "Барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт"-ыг нэгдүгээр, "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг сунгах аж ахуйн нэгж байгууллагын жагсаалт"-ыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Барилгын тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг яамны Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Гантулга/-т, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллахыг "Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ /Д.Цэрэнжигмэд/-д тус тус даалгасугай.



Б МӨНХБААТАР

151010798

Барилга, хот байгуулалтын сайдын 2021
оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 254
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ,
БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ШИНЭЭР
ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Барилгын ажлын төрөл	Хугацаа
1	"Хансесан" ХХК	Барилга угсралт, шинэ БА-2.1, 6.4, 7.1	5
2	"Оргил уулсын цамхаг" ХХК	Барилга угсралт, шинэ БА-2.1, 6.2, 6.3, 7.1	5

___оОо___

Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн
254 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ АЖ АХУЙН
НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Барилгын ажлын төрөл	Хугацаа
1	"Саруул монгол" ХХК	Барилга угсралт, сунгалт БА-6.1, 6.2,	5
2	"Ихжаргант" ХХК	Барилга угсралт, сунгалт БА-2.1, 3.1, 4.1, 6.3, 6.4, 7.1	5
3	"Батгүрэн" ХХК	Барилга угсралт, сунгалт БА-4.1, 6.1, 6.2, 6.3, 6.4, 7.1	5
4	"Азура-Архитектс" ХХК	Зураг төсөл, сунгалт ЗТ-2.1	5

___оОо___